

ОУИТБС-ЫН ӨГӨГДӨЛ МЭДЭЭЛЛИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН БОДЛОГО БА ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмаар Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын санаачилгын тайланг цахим хэлбэрээр илгээх, хүлээн авах, мэдээллийг ил тод болгох, цахим системийг хөтлөх, ОУИТБС-ын Нээлттэй мэдээллийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 ОУИТБС-ын цахим тайлагналын системийн /цаашид Цахим систем гэх/ програм хангамжийг боловсруулах, ОУИТБС-ын стандартад орсон өөрчлөлт, шинэчлэлтийн дагуу өргөжүүлэн хөгжүүлэх, хэвийн ажиллагааг хангах үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх ажлыг ОУИТБС-ын Ажлын алба хариуцна.
- 1.3 ОУИТБС-ын тайлан гаргадаг аж ахуйн нэгж болон төрийн холбогдох байгууллагууд энэхүү журмын дагуу цахим тайлагналын системд нэвтэрч холбогдох тайлангаа илгээнэ.
- 1.4 Цахим системд шаардлагатай лавлах мэдээлэл, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээлэл болон газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний талаарх мэдээллүүдийг холбогдох төрийн захиргааны байгууллагуудтай мэдээлэл солилцох гэрээ байгуулсны үндсэн дээр авч ашиглана.
- 1.5 ОУИТБС-ын хүрээнд цуглуулж, олон нийтэд ил тод болгохоор шийдвэрлэсэн мэдээллийг Санаачилгын цахим хуудас (<http://www.eitimongolia.mn>) болон Цахим тайлагналын системээр (<http://e-reporting.eitimongolia.mn>) дамжуулан олон нийтэд мэдээлнэ.
- 1.6 Цахим системийг ажиллагаанд дараах зарчмыг баримтална.
 - Тасралтгүй ажиллагаатай байх;
 - Тогтмол баяжуулах;
 - Үнэн зөв мэдээлэл оруулах;
 - Нээлттэй өгөгдлийн зарчмуудыг баримтлах;

ХОЁР. ЦАХИМ ТАЙЛАГНАЛЫН СИСТЕМ

- 2.1. Цахим систем нь ОУИТБС-ийн тайланг хүлээн авах, тулган баталгаажуулалтын дүгнэлтийг оруулах, олон нийтэд ил тод болгохоор тусгайлан зохиогдсон, вэб суурьтай програм хангамж байна.
- 2.2. Цахим систем нь дараах 5 төрлийн ялгаатай хандалтын түвшинтэй байна.
 - 2.2.1. Компани;
 - 2.2.2. Төрийн байгууллага;
 - 2.2.3. Аудитор;
 - 2.2.4. Иргэн, иргэний нийгмийн байгууллага;
 - 2.2.5. Системийн администратор;
- 2.3. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж буй компаниуд цахим системд анх нэвтрэхдээ бүртгэлийн хуудаст холбогдох мэдээллүүдээ оруулж хүсэлтээ илгээнэ.

- 2.4. Системийн администратор аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийг хянаж үзээд үнэн зөв бол нэвтрэх нэр, нууц үгийг цахим шуудангаар илгээнэ. Компаний хэрэглэгчийн нэвтрэх нэр нь тухайн аж ахуйн нэгжийн бүртгэлийн дугаар байна.
- 2.5. Төрийн байгууллагын болон аудитор хэрэглэгчдийн системд нэвтрэх бүртгэлийг системийн администратор үүсгэнэ.
- 2.6. Нэг байгууллагад системд нэвтрэх нэг эрх олгоно.

ГУРАВ. КОМПАНИЙ ХЭРЭГЛЭГЧИД ТАЙЛАГНАХ

- 3.1. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжүүд эрх бүхий байгууллагаас баталсан ОУИТБС-ын тайлангийн маягтын дагуу тогтоосон хугацаанд холбогдох тайланг үнэн зөв гаргаж цахим тайлагналын системээр илгээнэ.
- 3.2. Компаний хэрэглэгчид тайлагнах үедээ тухайн гарган өгсөн мэдээлэл нь бүрэн, үнэн зөв, аудитлагдсан санхүүгийн тайлан дээр үндэслэгдсэн болохыг баталгаажуулсан удирдлагын хариуцлагын захидлыг файл хэлбэрээр тайландаа хавсаргана.
- 3.3. Хэрэв тухайн компани хуулийн дагуу заавал хараат бус аудит хийлгэх шаардлагагүй бол энэ тухай удирдлагын хариуцлагын захидалдаа дурдсан байна.
- 3.4. Аж ахуйн нэгжүүд тухайн жилийн тайлангаа системд оруулж “Илгээх” товчийг дарж илгээснээр тайлан олон нийтэд ил тод болно.
- 3.5. Тайлагнах хугацаанаас хоцорсон, эсвэл хугацаа дууссаны дараа тайланг засварлах шаардлага гарсан тохиолдолд цахим системээр дамжуулан хүсэлт илгээж болно.
- 3.6. Тайлагнагч аж ахуйн нэгж нь системд бүртгэгдсэн өөрийн компаний утас, хаяг, цахим шуудан, удирдлага, үйл ажиллагааны чиглэл гэх мэт холбогдох мэдээллүүдийг тогтмол шинэчилнэ.

ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ТАЙЛАГНАХ

- 4.1. ОУИТБС-ын тайлан гаргадаг төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагууд эрх бүхий байгууллагаас баталсан ОУИТБС-ын тайлангийн маягтын дагуу тогтоосон хугацаанд холбогдох тайланг үнэн зөв гаргаж цахим тайлагналын системээр илгээнэ.
- 4.2. Тайлан гаргаж буй төрийн байгууллага тайланд өгсөн мэдээлэл нь үнэн зөв болохыг баталгаажуулсан эрх бүхий этгээдийн албан бичгийг файл хэлбэрээр хавсаргана.
- 4.3. Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагууд холбогдох тайлангаа системд оруулж “Илгээх” товчийг дарж илгээснээр тайлан олон нийтэд ил тод болно.

ТАВ. ТУЛГАН БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ

- 5.1. Системийн администратор тухайн жилд ОУИТБС-ын тулган баталгаажуулалтыг хийхээр зохих журмын дагуу сонгогдсон аж ахуйн нэгжид Аудитор хандалтын түвшинтэй хэрэглэгч үүсгэж системд нэвтрэх нэр, нууц үгийг илгээнэ.
- 5.2. Тухайн жилд ОУИТБС-ын тайлангийн тулган баталгаажуулалтад хамрагдах аж ахуйн нэгжүүдийг тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу сонгоно.
- 5.3. Тулган баталгаажуулалт хийж буй аудитын байгууллага өөрийн хэрэглэгчийн нэр, нууц үгийг ашиглан цахим системд нэвтэрч сонгогдсон аж ахуйн нэгжүүдийн

тайлантай танилцах бөгөөд аж ахуйн нэгжүүдийн тайланд шаардлагатай тохируулга, дүгнэлтүүдийг цахим системд оруулж хадгална.

- 5.4. Тулган баталгаажуулалтын явцад тайлагнагч аж ахуйн нэгж байгууллагуудаас нэмэлт мэдээлэл хүсэх шаардлага гарсан бол ОУИТБС-ын Стандарт болон бусад холбогдох журмын дагуу боловсруулсан маягтын дагуу цахим тайлагналын системээр мэдээлэл цуглуулж болно.

ЗУРГАА. НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН БОДЛОГО

ОУИТБС-ын нээлттэй өгөгдөл, мэдээлэлд дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

6.1. Бүрэн бүтэн байх

Гаргасан тоо баримт нь аль болох бүрэн гүйцэд байх ёстой. Энэ нь ОУИТБС-ын үйл ажиллагааны хүрээнд баримтжуулсан хамрах хүрээг бүхэлд нь илэрхийлж байх ёстой. Ямар нэг хууль зөрчихгүй тохиолдолд тухайн тайлан мэдээнд ашигласан бүхий л боловсруулагдаагүй эх мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй байлгана. Хуулийн дагуу хамгаалах ёстой хувийн мэдээлэл болон бусад нууц мэдээллийг агуулсан, түүнчлэн Олон талын оролцоот бүлгийн шийдвэрээр нийтлэхгүй байхаар шийдсэн мэдээллийг олон нийтэд түгээхгүй байж болно. Боловсруулаагүй эх мэдээллийг тайлбарласан эсвэл энэ тухай тайлбар өгсөн Мета мэдээллийг хуваалцах ёстой ба үүнд түүнийг хэрхэн тооцсон тухай томъёо, тооцооллын тайлбартай хамт өгнө. Энэ нь хэрэглэгчдэд ОУИТБС-ын мэдээллийн агуулгыг бүрэн ойлгож, элемент бүрийг нарийвчлан үзэх боломжийг олгодог.

6.2. Суурь эх үүсвэр байх

ОУИТБС-ын хүрээнд гаргасан тайлан мэдээ нь суурь эх үүсвэртэй байх ёстой бөгөөд тухайн мэдээллийг хэрхэн олж авсан арга зүй, судалгаагаар баримтжуулах эх үүсвэр зэрэг багтсан байх ёстой. Олон нийтэд түгээсэн мэдээлэл нь ОУИТБС-ын мэдээллийг хэрэглэгчид мэдээллийн зохих ёсоор олж авсан эсэх, үнэн зөв бодитоор баталгаажуулсан эсэхийг шалгах боломжийг олгодог.

6.3. Цаг тухайд нь мэдээллийг гаргах

ОУИТБС-ын гаргасан тайлан мэдээ нь аль болох богино хугацааны дотор олон нийтэд нээлттэй болох ёстой. Мэдээллийн ач холбогдол нь цаг хугацаанаас хамаарах мэдээлэл нэн тэргүүлэх зэрэглэлийн ач холбогдол өгөх ёстой.

6.4. Хялбархан олж авах боломжтой байх

ОУИТБС-ын гаргасан тайлан мэдээ нь олж авахад аль болох хялбар, хүртээмжтэй байх ёстой. Өгөгдлийн санд байгаа мэдээллийг төрөл бүрийн хэлбэрээр татаж авах боломжийг бүрдүүлсэн байна. Мөн санаачилгын талаарх мэдээллийг төрөл бүрээр хайж олох боломжийг бүрдүүлсэн байна.

6.5. Машинаар уншигддаг байх

ОУИТБС-ын мэдээллийг машинаар уншиж болохуйц XLS, CSV, XML болон JSON гэх мэт файл хэлбэрээр түгээнэ. Мөн тухайн мэдээлэл нь түүнийг хэрхэн ашиглах талаар тайлбарласан бичиг баримтын хамт байх ёстой.

6.6. Үл ялгаварлах

ОҮИТБС-ын мэдээлэлтэй танилцах хүсэлтэй хэрэглэгчид өөрсдийгөө хэн гэдгийг тодорхойлохгүйгээр эсвэл өөрийн үйлдлийг тайлбарлах шаардлагагүйгээр хэзээ ч хамаагүй өгөгдөлд хандах боломжтой байна. ОҮИТБС-ын цахим хуудас болон мэдээллийн портал нь ялгаварлан гадуурхалгүйгээр нэвтрэх зарчмыг хангасан байна.

6.7. Лицензгүй байх

ОҮИТБС-ын мэдээллийг цааш дахин түгээхэд лицензийн ямар нэг хязгаарлалтгүй байх бөгөөд зөвхөн эх үүсвэрийг дурдахыг шаардана.

6.8. Үнэ төлбөргүй ашиглах

ОҮИТБС-тай холбоотой бүх мэдээллийг үнэ төлбөргүйгээр авах боломжтой байна.

ДОЛОО. БУСАД

- 7.1. Цахим системийг ашиглаж буй бүх төрлийн хэрэглэгчид өөрт нь эрх олгогдоогүй үйлдэл хийхээр турших, бусдын мэдээллийг өөрчлөхийг оролдох, системийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах аливаа оролдлого хийх зэргээр системийг зүй бусаар ашиглахыг хориглоно.
- 7.2. Системийн администратор цахим системийн програм хангамжийн эх код, өгөгдлийн санг сар бүр нөөцлөн авч DVD-д бичиж хадгална.